



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дүгээр сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн өмчөөс шилжүүлсэн 5,006,790.00 (таван сая зургаан мянга долоон зуун ерэн) төгрөгийн балансын үнэ, 1,599,391.25 (нэг сая таван зуун ерэн есөн мянга гурван зуун ерэн нэгэн төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Дархан-Уул аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 445 дугаар нээлттэй хорих ангийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Загджав, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Баасанжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Шилжүүлж буй үл хөдлөх хөрөнгөд хамаарах газар эзэмших эрхийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу Дархан-Уул аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 445 дугаар нээлттэй хорих ангийн нэр дээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201075

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 03
дугаар сарын 09-ний өдрийн 56
дугаар тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧӨӨС ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ 445 ДУГААР НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон он	хэм жих нэгж	тоо шир хэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Хүнсний ногооны зоорь	2018	м2	40	5,006,790.00	1,599,391.25	3,407,398.75
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН				5,006,790.00 (таван сая зургаан мянга долоон зуун ерэн)	1,599,391.25 (нэг сая таван зуун ерэн есөн мянга гурван зуун ерэн нэгэн төгрөг хорин таван мөнгө)	3,407,398.75 (гурван сая дөрвөн зуун долоон мянга гурван зуун ерэн найман төгрөг далан таван мөнгө)